



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

2026 оныг “Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих” жил” болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Нийслэл, дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2025 оны зорилтот жилийн ололт, амжилтыг бататган аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал санаачилгыг дэмжих, үйлдвэр үйлчилгээний чанар хүртээмжийн нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн хэмжээнд 2026 оныг “Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих жил” болгон зарласугай.

2.Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэдийн саналыг тусган боловсруулж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

4.Зорилтот жилийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээг байгууллага, нэгж бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган үр дүн гаргаж ажиллахыг Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

5.Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган, явц үр дүнг хагас жил, жилийн эцсийн байдлаар нэгтгэн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, мэдээллийг иргэд, олон нийтэд сурталчлан ажиллахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 01 сарын 02-ны өдрийн
А/01 дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч: Засаг даргын орлогч
Гишүүд: Дүүргийн менежер
Засаг даргын Тамгын газрын дарга
Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зохион
байгуулалтын хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Нэгдүгээр хорооны Засаг дарга
Хоёрдугаар хорооны Засаг дарга
Газар зохион байгуулалтын албаны дарга
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга
Багахангай Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвийн
захирал
Багахангайн Үйлдвэрлэл, технологийн парк ХК-ны захирал

Нарийн бичгийн
дарга Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга